



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 9/17

Улаанбаатар хот

### Хан-Уул дүүргийн 65 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг дахин үнэлж, балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2023 оны А/15 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хан-Уул дүүргийн 65 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 420,000 (дөрвөн зуун хорин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Хан-Уул дүүргийн 300 дугаар цэцэрлэгийн баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Хан-Уул дүүргийн 65 дугаар цэцэрлэг (Б.Баярмаа)-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу дахин үнэлсэн дүнгээр бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийхийг Хан-Уул дүүргийн 300 дугаар цэцэрлэг (А.Ариунаа)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэст даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500058

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
2024 оны 08 дугаар сарын 15 -ний өдрийн  
А/17... дугаар тушаалын хавсралт



### Дахин үнэлж, шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 65 дугаар цэцэрлэг

№	Нэр төрөл	Ашиглалтад орсон огноо	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Цаашид ашиглах жил	Шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Хөрөнгө шилжүүлж авах байгууллагын нэр
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
<b>Тоног төхөөрөмж</b>													
1	Буузны жигнүүр	2012.09.10	11	ш	1	420,000	420,000.00	420,000.00	-	3	210,000.00	210,000.00	300 дугаар цэцэрлэг
<b>Машин тоног төхөөрөмжийн дүн</b>							<b>420,000.00</b>					<b>210,000.00</b>	